

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Хөвсгөл аймгийн Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлан**

Аудитын код: ХӨА-2025/045/НА-СТА-ТШЗ

Цахим
www.audit.mn

Мөрөн сум
2025 он

хуудас:

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас:88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Аудитор Г. Сувд

Утас: 99382220 Цахим хаяг: g.suvd2018@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
Асуудлыг онцолсон хэсэг	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.2 Албан шаардлага	15
5.3 Зөвлөмж	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/175
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Л. БАЯРСАЙХАН ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Жаргалант сумын эрүүл мэндийн төв нь 2024 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,233,307.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаас 1,059,954.8 мянган төгрөгийг санхүүжилтийг авч 173,352.3 мянган төгрөгийн авлагатай гарсан нь өмнөх жилээс авлага 9,3 дахин нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй

Аудитаар нийт 29,346.9 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчлийг илрүүлснээс 27,935.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 609.7 төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж өгч, 802.2 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн,

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Жаргалант сумын эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2024 оны гэрээний биелэлтийг 88.6 хувьтай дүгнэсэн байна.

БҮГДЭМ

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	157,354,395.01	296,920,778.23
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	22,356,575.52	19.10
312	Банканд байгаа бэлэн мөнгө	22,356,575.52	19.10
3121	Төгрөг	22,356,575.52	19.10
31211	Төрийн сангийн харилцах	22,356,575.52	19.10
33	АВЛАГА	19,614,360.98	173,652,307.15
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,035,055.98	300,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	18,579,305.00	173,352,307.15
35	БАРАА МАТЕРИАЛ	115,383,458.51	123,268,451.98
351	Түүхий эд материал	38,128,864.69	39,540,212.69
35130	Эм боох материал	38,128,864.69	39,540,212.69
354	Хангамжийн материал	77,254,593.82	83,728,239.29
35410	Бичиг хэргийн материал	1,346,700.00	2,541,970.00
35420	Аж ахуйн материал	6,315,100.00	5,027,400.00
35430	Сэлбэг хэрэгсэл	950,000.00	2,575,000.00
35440	Түлш, шатах тослох материал	565,122.27	491,412.27
35450	Барилгын засварын материал	5,675,300.00	8,054,800.00
35460	Хүнсний материал	6,256,016.09	6,137,988.59
35470	Бусад хангамжийн материал	56,146,355.46	58,899,668.43
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	759,420,238.92	850,339,432.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	759,420,238.92	850,339,432.94
392	Биет хөрөнгө	744,284,238.92	835,203,432.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	668,023,880.00	668,023,880.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-89,388,672.82	-113,349,434.62
39203	Авто-тээврийн хэрэгсэл	71,739,238.00	112,340,019.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-50,736,229.99	-29,983,519.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	273,016,243.20	357,413,703.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-147,937,214.12	-185,973,690.14
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	45,718,100.00	59,684,600.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26,151,105.35	-32,952,125.10
393	Биет бус хөрөнгө	15,136,000.00	15,136,000.00
39301	Программ хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	15,136,000.00	15,136,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	916,774,633.93	1,147,260,211.17
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,058,707.12	75,578,789.65
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,058,707.12	75,578,789.65

413	Өглөг	1,058,707.12	75,578,789.65
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	21,809,190.31
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	44,712,399.34
4136	Бусад өглөг	1,058,707.12	9,057,200.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	9,057,200.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	915,715,926.81	1,071,681,421.52
51	Засгийн газрын хувь оролцоо	915,715,926.81	1,071,681,421.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	385,375,911.00	385,375,911.00
51101	Өмч: - төрийн	385,375,911.00	385,375,911.00
512	Хуримтлагдсан үр дүн	319,647,926.76	475,613,421.47
51210	Өмнөх үеийн үр дүн	319,647,926.76	319,647,926.76
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	155,965,494.71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	210,692,089.05	210,692,089.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	916,774,633.93	1,147,260,211.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,026,868,400.62	1,470,874,747.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	75,864,327.67	182,734,413.10
120	Нийтлэг татварын бус орлого	75,864,327.67	182,734,413.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	75,864,327.67	182,734,413.10
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	75,864,327.67	182,734,413.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	951,004,072.95	1,288,140,334.17
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	32,582,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	32,582,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	40,525,000.00	40,830,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40,525,000.00	40,830,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	910,479,072.95	1,214,727,834.17
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	910,479,072.95	1,214,727,834.17
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	998,850,734.59	1,311,234,252.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	998,850,734.59	1,311,234,252.56

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	995,658,672.97	1,279,042,559.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	571,950,043.12	824,249,175.30
210101	Үндсэн цалин	392,006,433.12	516,372,228.50
210102	Нэмэгдэл	119,736,255.00	230,883,796.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,660,000.00	37,621,000.00
210104	Урамшуулал	54,547,355.00	39,372,150.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,514,583.55	98,224,132.98
210201	Тэтгэврийн даатгал	51,907,667.92	66,498,713.89
210202	Тэтгэмжийн даатгал	5,797,068.96	8,085,822.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,026,175.82	5,389,231.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,071,240.97	3,673,233.22
210205	Эрүүл мэндийн даатгал	10,712,429.88	14,577,132.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,832,938.38	34,720,807.00
210301	Гэрэл, цахилгаан	3,636,714.38	3,767,851.00
210302	Түлш, халаалт	27,196,224.00	28,852,956.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	2,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	92,403,903.12	82,639,480.93
210401	Бичиг хэрэг	6,028,300.00	4,961,100.00
210402	Тээвэр, шатахуун	35,616,300.00	39,589,470.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,684,000.00	2,400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	33,814,750.00	16,912,989.50
210408	Бараа материал акталсны зардал	14,260,553.12	18,775,921.43
2105	Нормативт зардал	126,678,657.90	132,238,882.37
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	108,068,583.40	114,472,204.87
210502	Хоол, хүнс	18,610,074.50	17,766,677.50
2107	Томилолт, зочны зардал	2,292,000.00	1,892,000.00
210702	Дотоод албан томилолт	2,292,000.00	1,892,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,185,800.00	15,021,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,623,000.00	15,021,000.00
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	00.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,100,746.90	90,057,080.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,007,000.00	6,323,215.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	78,093,746.90	83,733,865.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,192,061.62	32,191,693.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	30,582,000.00

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	30,582,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,192,061.62	1,609,693.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,192,061.62	1,609,693.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	28,017,666.03	159,640,494.71
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	995,999.92	3,675,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	995,999.92	3,675,000.00
225003	Хөрөнгө оруулалтын гарз		
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-995,999.92	-3,675,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	27,021,666.11	155,965,494.71

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	971,574,087.05	1,133,367,332.02
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	971,574,087.05	1,133,367,332.02
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	32,582,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	32,582,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	40,525,000.00	40,830,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40,525,000.00	40,830,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	891,899,767.95	1,059,954,832.02
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	891,899,767.95	1,059,954,832.02
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	894,427,511.53	1,122,910,888.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	894,427,511.53	1,122,910,888.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	891,235,449.91	1,090,719,195.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	570,891,336.00	802,763,636.13
210101	Үндсэн цалин	376,190,706.93	515,154,499.31
210102	Нэмэгдэл	140,888,734.07	234,007,486.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,628,440.00	37,422,000.00
210104	Урамшуулал	48,183,455.00	16,179,650.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,569,763.53	98,224,132.98
210201	Тэтгэврийн даатгал	51,961,847.96	67,036,461.77
210202	Тэтгэмжийн даатгал	5,797,069.08	7,018,080.42

210203	ҮОМШӨ-ний даатгал	5,026,175.49	4,844,409.23
210204	Ажилгүйдлийн даатгал	1,072,240.81	3,865,216.16
210205	Эрүүл мэндийн даатгал	10,712,430.19	15,459,965.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,832,938.38	34,720,807.00
210301	Гэрэл, цахилгаан	3,636,714.38	3,767,851.00
210302	Түлш, халаалт	27,196,224.00	28,852,956.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	2,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	57,556,220.00	52,253,683.13
210401	Бичиг хэрэг	2,898,000.00	2,844,000.00
210402	Тээвэр, шатахуун	35,781,220.00	38,027,883.13
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,684,000.00	2,400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,193,000.00	8,981,800.00
2105	Нормативт зардал	104,885,642.00	78,038,036.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	73,633,852.00	65,272,136.20
210502	Хоол, хүнс	15,251,790.00	6,965,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,000,000.00	5,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,249,300.00	4,500,000.00
210604	Урсгал засвар	26,249,300.00	4,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,292,000.00	1,892,000.00
210702	Дотоод албан томилолт	2,292,000.00	1,892,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,097,050.00	16,270,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,068,000.00	15,021,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,466,250.00	1,249,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,861,200.00	2,056,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,861,200.00	2,056,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,192,061.62	32,191,693.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	30,582,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	30,582,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,192,061.62	1,609,693.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,192,061.62	1,609,693.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	77,146,575.52	10,456,443.58
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	54,790,000.00	32,813,000.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54,790,000.00	32,813,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	54,790,000.00	32,813,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	54,790,000.00	32,813,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-54,790,000.00	-32,813,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	22,356,575.52	-22,356,556.42
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	39,149,319.10	22,356,575.52
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,356,575.52	19.10

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2023 оны 12-р сарын 31-нэрэх үлдэгдэл	385,375,911.00	210,692,089.05	319,647,926.76	915,715,926.81
D01	2024 оны 12-р сарын 31-нэрэх үлдэгдэл	385,375,911.00	210,692,089.05	319,647,926.76	915,715,926.81
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	385,375,911.00	210,692,089.05	319,647,926.76	915,715,926.81
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	155,965,494.71	155,965,494.71
D09	2025 оны 12-р сарын 31-нэрэх үлдэгдэл	385,375,911.00	210,692,089.05	475,613,421.47	1,071,681,421.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		хувь	Өөрчлөлт
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,259,249,200.00	1,114,893,388.44	88.54	144,355,811.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,259,249,200.00	1,114,893,388.44	88.54	144,355,811.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,179,249,200.00	1,084,311,388.44	91.95	-94,937,811.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	829,812,800.00	802,763,636.13	96.74	-27,049,163.87
210101	Үндсэн цалин	546,700,000.00	515,154,499.31	94.23	-31,545,500.69
210102	Нэмэгдэл	214,136,800.00	234,007,486.82	109.28	19,870,686.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,720,000.00	37,422,000.00	429.15	28,702,000.00
210104	Урамшуулал	60,256,000.00	16,179,650.00	26.85	-44,076,350.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,726,700.00	98,224,132.98	94.70	-5,502,567.02
210201	Тэтгэврийн даатгал	70,534,100.00	67,036,461.77	95.04	-3,497,638.23
210202	Тэтгэмжийн даатгал	8,298,100.00	7,018,080.42	84.57	-1,280,019.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,149,100.00	4,844,409.23	116.76	695,309.23
210204	Ажилгүйдлийн даатгал	4,149,100.00	3,865,216.16	93.16	-283,883.84
210205	Эрүүл мэндийн даатгал	16,596,300.00	15,459,965.40	93.15	-1,136,334.60
2104	Хангамж, бараа материалын зардал	68,253,900.00	52,253,683.13	76.56	-16,000,216.87
210401	Бичиг хэрэг	4,308,700.00	2,844,000.00	66.01	-1,464,700.00
210402	Тээвэр, шатахуун	33,125,700.00	38,027,883.13	114.80	4,902,183.13
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,016,100.00	2,400,000.00	79.57	-616,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,078,100.00	8,981,800.00	98.94	-96,300.00
2105	Нормативт зардал	99,636,000.00	78,038,036.20	78.32	-21,597,963.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	70,737,000.00	65,272,136.20	92.27	-5,464,863.80
210502	Хоол, хүнс	22,898,800.00	6,965,900.00	30.42	-15,932,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,000,200.00	5,800,000.00	96.66	-200,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,813,000.00	32,813,000.00	100.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,125,200.00	17,813,000.00	160.11	6,687,800.00
210602	Тавилга	8,055,600.00	15,000,000.00	186.21	6,944,400.00

2107	Томилолт, зочны зардал	4,500,000.00	1,892,000.00	42.04	-2,608,000.00
210702	Дотоод албан томилолт	4,500,000.00	1,892,000.00	42.04	-2,608,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,967,900.00	16,270,900.00	56.17	-12,697,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,057,900.00	15,021,000.00	57.64	-11,036,900.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,154,000.00	1,249,900.00	58.03	-904,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11538900.00	2056000.00	17.82	-9,482,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,538,900.00	2,056,000.00	17.82	-9,482,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,000,000.00	30,582,000.00	38.23	-49,418,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	80,000,000.00	30,582,000.00	38.23	-49,418,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	80,000,000.00	30,582,000.00	38.23	-49,418,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,259,249,200.00	1,092,536,832.02	86.76	-166,712,367.98
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих				0.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,177,249,200.00	1,059,954,832.02	90.04	-117,294,367.98
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,177,249,200.00	1,059,954,832.02	90.04	-117,294,367.98
1311	НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	82,000,000.00	32,582,000.00	39.73	-49,418,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	82,000,000.00	32,582,000.00	39.73	-49,418,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	22,356,575.52		22,356,575.52
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	19.10		19.10
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	33.00	33.00	100.00	0.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	100.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	25.00	25.00	100.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00	100.00	0.00

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Өөрчлөлт	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40,830,500.00	40,830,500.00		100
21	УРСГАЛ ЗАРДАЛ	40,830,500.00	39,220,807.00	0.00	96.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,330,500.00	34,720,807.00	-1,609,693.00	95.6
210301	Гэрэл, цахилгаан	3,700,000.00	3,767,851.00	-1,609,693.00	101.8
210302	Түлш, халаалт	28,030,500.00	28,852,956.00	67,851.00	102.9
210303	Цэвэр, бохир ус	4,600,000.00	2,100,000.00	822,456.00	45.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,500,000.00	4,500,000.00	-2,500,000.00	100
210604	Урсгал засвар	4,500,000.00	4,500,000.00	0.00	100
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,609,693.00	0.00	
79	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		1,609,693.00	1,609,693.00	
81	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		1,609,693.00	1,609,693.00	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	40,830,500.00	40,830,500.00	1,609,693.00	100
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	40,830,500.00	40,830,500.00	0.00	100
132001	Орон нутгийн төсвөөс	40,830,500.00	40,830,500.00	0.00	100

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 29,346.9 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчлийг илрүүлснээс 27,935.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 609.7 төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж өгч, 802.2 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн,

5.1 Залруулсан алдаа:

Т.Батмөнх /Цэцхүү Трейд/ ХХК-аас хандиваар өгсөн 27,935.0 мянган төгрөгийн бараа, материал тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн тодруулга, бараа материалын тодруулгад "бусад" эх үүсвэрээс гэж бүртгэсэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалт "үнэн зөв байх;" заалттай нийцэхгүй "үнэлгээ ба хуваарилал" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул хандиваар бүртгүүлж залруулга хийсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 802.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс доогуур байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.2 Албан шаардлага

- Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг 20.0 сая төгрөгөөр тогтоосон байхад тус эрүүл мэндийн төв нь эмийн шууд худалдан авалтыг хязгаараас 30,835.7 мянган төгрөгөөр давсан дүнгээр худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.” заалттай нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа
- Засгийн Газрын 2023 оны 241 тоот тушаалын 6-р хавсралтаар батлагдсан "Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ"-ээс хэтрүүлэн олгосон 802,2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнтэй холбоотой болон бусад шинээр гарсан дүрэм, журамтай нийцэхгүй болсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.” заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамтай нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөх.

2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, эмийн зардлыг оруулалгүй орхигдуулсан, тайлант жилийн төсөвт орсон өөрчлөлтийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.”, 48 дугаар зүйлийн 48.2.1 “Худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах;” заалт, Сангийн сайдын 2023 оны А/250 тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.11 “Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах ба энэ журмын 2.12-т заасан үндэслэлээр батлагдсан төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлөвлөгөөнд өөрчлөлтийг тусган, батална. Хэрэв холбогдох дээд шатны байгууллага байгаа бол төлөвлөгөөний

өөрчлөлтийг түүгээр батлуулахаар цахим системээр илгээж, өөрчлөлтийг баталгаажуулна.” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант оны төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг төлөвлөх, төсөвт өөрчлөлт орсон тухай бүрд нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлтийг оруулж батлуулж байх.

3. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн асуудал

Илрүүлэлт:

Жаргалант сумын эрүүл мэндийн төв нь 2024 онд сумын иргэдэд үзүүлсэн тусламж, үйлчилгээний санхүүжилт 1,246,481,105.17 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас нэхэмжилснээс 31913,2 мянган төгрөг хасагдсаны нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 “эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх”, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоолын 3.1 “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж,..” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны цахим системийн дотоод хяналтыг сайжруулж, хасагдалтын хэмжээг өмнөх оноос бууруулах.

4. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 23 гүйлгээ, зарлагын 6 гүйлгээ, төсөв өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 13 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн, дараа жилийн төсвийн төсөл, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож мэдээлсэн нь “Шилэн дансны тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;” заалт, 6 дугаар зүйлийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;” заалт болон “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах

5. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт

- Бараа материалын үлдэгдэлд бүтэн жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн 609,7 мянган төгрөгийн эмийн үлдэгдэл байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 “нөөцлөх шаардлагатай бараа,

материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;" заалтыг хэрэгжүүлээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эмийн үлдэгдэл, хэрэгцээ шаардлагыг бодитоор тооцон эмийн захиалгыг өгч, материалын үлдэгдлийг эхэлж авснаа, эхэлж зарлагдах, эмийн хадгалалтын хугацаанд байнга хяналт хийж, холбогдох арга хэмжээг тухай бүр авч байх.

6. Ахмадын сангийн талаар

Илрүүлэлт:

Жаргалант сумын эрүүл мэндийн төв нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нээж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах..." гэж заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын цалингийн сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр Ахмадын сан байгуулах хөрөнгийг төсөвт тусган хэрэгжүүлэх

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Хандиваар өгсөн материал тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн тодруулга, бараа материалын тодруулгад "бусад" эх үүсвэрээс гэж бүртгэсэн	1	27,935.0	1		1	27,935.0	1	27,935.0		
Дүн	1	27,935.0	1		1	27,935.0	1	27,935.0		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эрүүл мэндийн төвийн дарга Л.Баярсайханы албан тушаалын жишиг цалингийн хэмжээг нэмэгдүүлэн олгосон	1	802,2			1	802,2		
Нягтлан бодох бүртгийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамд нийцүүлэн шинэчлээгүй.	1	-					1	-
Дүн	2	802,2			1	802,2	1	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллүүдийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	0					1	0
Эм, эмнэлгийн хэрэгслэлийн шууд худалдан авалтын дүн шууд худалдан авах дээд хязгаараас давсан.	1	0			1			
Зарим зардлыг ХАА-ны төлөвлөгөөнд тусгаагүй. худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг tender.gov.mn –д байршуулаагүй.	1	-					1	-
Эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг цахим системд бүрэн, үнэ зөв оруулаагүйгээс нэхэмжилсэн санхүүжилтийг бүрэн авч чадаагүй.	1						1	
Бараа материалын үлдэгдэлд жилийн турш хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн эмийн үлдэгдэлтэй байна.	1	609,7					1	609,7
Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж, батлуулаагүй	1	-					1	-
ДҮН	6	609,7			1		5	609,7



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

№ 33/А2270469/

Мөрөн сум

ХАА - 2025/045/МА - АТ - ТИЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд Жаргалант сумын Засаг даргын 2023 оны Б/24 тоот захирамжаар Сумын эрүүл мэндийн төвийн дарга Л. Баярсайханы албан тушаалын үндсэн цалинг Засгийн газрын Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар тогтоосон "Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ"-г нэмэгдүүлэн тогтоосноос нийт 802,200 (найман зуун хоёр мянга хоёр зуун) төгрөгийн цалин илүү олгосон байна.

Дээрх зөрчил нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.14-т "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.", Эрүүл мэндийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т "Эрүүл мэндийн ажилтны цалингийн тусгай сүлжээний доод жишгийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, онцлогийг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;" гэж заасантай тус тус нийцэхгүй," үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3. "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ** :

1. Албан хаагчдын цалинг тогтооходоо хүчин төгөлдөр мөрдөж буй цалингийн сүлжээг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 20-ны дотор гаргаж, төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд оруулж, баталгаажуулах;

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Засаг дарга Д.Амарбаясгалан, Эрүүл мэндийн төвийн дарга Л.Баярсайхан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

Г.ИЧИНХОРЛОО

67240 90547



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

№ 34/102270469/

Мөрөн сум

ХӨА-2025/045/НА-СТ-ТМС

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эмийн шууд худалдан авалтын дүн нь "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор тогтоосон шууд худалдан авч болох барааны төсөвт өртгийн дээд хязгаараас 30,835,700 (Гучин сая найман зуун гучин таван мянга долоон зуу) төгрөгөөр хэтэрсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно." заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Засгийн газраас тогтоосон шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлан ажиллаж, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны едрийн дотор гаргаж, төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд оруулж, баталгаажуулах;
2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн дарга Л.Баярсайхан, нягтлан бодогч Ж.Баттүшиг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

Г.ИЧИНХОРЛОО

6724030538

